

ЗАМ ГҮҮРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
ИНЖЕНЕР-ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨХ
“ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

ТАЙЛБАР БИЧИГ

“А26 Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн 54.176км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил”

Шаргалжуут голын 60у/м төмөрбетон гүүр

УЛААНБААТАР 2013 он

ЗАМ ГҮҮРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
ИНЖЕНЕР-ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨХ
“ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК

ТАЙЛБАР БИЧИГ

“А26 Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн 54.176км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил”

Шаргалжуут голын 60у/м төмөрбетон гүүр

Гүйцэтгэх захирал **КИМ СОН ХУАН**

Ерөнхий инженер **Н.НЯМСҮРЭН**

УЛААНБААТАР 2013 он

1. Төслийн танилцуулга

Баянхонгор-Шаргалжуут чиглэлд барих 54.176км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын ПК.15+210.0 ~ ПК.15+270.0 байрлалтай 60м-ийн урт гүүрийн зураг төсөл юм.

Байршлын тойм зураг:

Гүүрийн бүтэц :

- Гүүрийн урт : L=4*15.0=60.0m
- Гүүрийн өргөн : 0.9+2.000+2@3.500+2.000+0.9=11.09
- Дээд хэсгийн бүтээцийн байдал : Үргэлжилсэн хавтант дам нуруутай төмөр бетон гүүр
- Дагуу огтлол : (+)0.4924%
- Дэвсгэр: шулуун
- Гүүрийн тулгуур : Т хэлбэр
- Суурийн хэлбэр: энгийн суурь

Дэвсгэр зураг	
Хөндлөн огтлолын зураг	
Огтлолын зураг	

2. Гүүрийн төлөвлөгөө

А. Гүүрийн уртын төлөвлөгөө

Объектын судалгаа:

Гүүр барихаар сонгосон талбайд бол саарал өнгөтэй чийгтэй- усаар ханасан элсэн чигжээстэй сайр, сайрган хөрс, Палезойн настай ягаандуу, цайвар саарал өнгөтэй элсэн чулууг хучиж тогтсон байна. Элсэн чигжээстэй сайр, сайрган хөрс бул чулуу агуулна.



Гүүрийн ойр орчим

Төв азийн гадагш урсацгүй голуудын ай савд буюу Хангайн өмнөх говийн нууруудын ус хураах талбайд ордог гол юм. Энэ гол ойролцоогоор 85км урсаад Түйн голын зүүн гарт цутгана. Нийт ус хураах талбай нь 1875км^2 орчим болно. /Дэлгэрэнгүйг Ус зүйн судалгааны тайлангаас үзнэ үү./

Б. Уртын харьцуулалтын судалгаа:

Одоогийн байдлаар усны хэмжээ харьцангуй их хэмжээтэй ба чөлөөтэй урсах урсгалыг тогтоосон бөгөөд, энгийн үед урсах голын гүний хэмжээг багасгалгүй гүүрийн уртыг 60м-ээр төлөвлөсөн. Үүнээс үүдэн гүүрийн их усны түвшинг 1883.02м гэж тооцсон.

	Их урсац	
	2%	1%
Урсац /м3/сек/	367.84	418
Түвшин /м/	1882.92	1883.02
Түвшин хашигдсан 60м	EL : 1883.02	1883.24

Ангилал	Дагуу огтлол
Хувилбар 1	 Гүүрийн урт : 18+18+18=54m Гүүрийн хэлбэр: Үргэлжилсэн хавтант дам нуруутай төмөр бетон гүүр (1.395m) Үерийн усны зарцуулга : 431.3m^3/sec(> $Q_{1\%}$ = 418.0 m^3/sec) Үерийн усны төвшин : газрын гадаргаас дээш 3.0m хүртэл Гүүрийн доод хэсгийн чөлөөт зай: 0.97m
Хувилбар 1	 Гүүрийн урт : 4@15=60m Гүүрийн хэлбэр : Үргэлжилсэн хавтант дам нуруутай төмөр бетон гүүр (дам нуруу 0.88m) Үерийн усны зарцуулга : 430.0m3/sec(> $Q_{1\%}$ = 418.0 m^3/sec) Үерийн усны төвшин : газрын гадаргаас 2.7m хүртэл Гүүрийн доод хэсгийн чөлөөт зай : 1.77m

Гүүр байгаа хэсгийн газрын гадарга нь өргөн, тэгш гадаргатай бөгөөд хур тундастай үед усанд автах аюултай. Энгийн дөрвөлжин хоолой суурьлуулсан тохиолдолд шар ус гадагшлуулах эзлэхүүн шаардлагатай хэмжээнд байж чадахгүй учир бүтээцийн төлөвлөлт зайлшгүй хийх шаардлагатай.

Хувилбар 1-т гүүрийн уртыг 54 метрээр тооцоход усны төвшин газрын гадаргаас дээш 3 метр хүртэл дээшилж усанд автах талбайн хэмжээ нэмэгдэнэ. Мөн дам нуруу өн дөр учраас (H=1.395м) гүүрийн доод хэсгийн чөлөөт зай 1.0м-с илүү байхаар тооцох боломжгүй юм.

Хувилбар 2-т гүүрийн уртыг 60 метрээр тооцоход усны төвшин газрын гадаргаас 2,7 метр хүртэл дээшилж усанд автах талбай харьцангуй бага байх ба дам нуруу нам учраас (H=0.88м) гүүрийн доод хэсгийн чөлөөт зайг 1,0 метрээс дээш болгох боломжтой. Үүнээс харахад гүүрийн урт усны тооцооны хувьд боломжтой бөгөөд гүүрийн доод хэсгийг өргөтгөж болохоор буюу **60** метрээр тооцов.

В. Гүүрийн өргөнийг шалгах:

Уг замын төлөвлөсөн өргөн нь 11.0м бөгөөд гүүрийн нийт урт нь 60м(алгаслал нь 6) юм. Тиймээс зургийн жишиг стандарт (БНбД-32.02.03 -т заасан 1.51зүйл)-ын дагуу замын стандарт өргөн (11м)-ийг баталгаажуулсан бөгөөд гүүрийн өргөнд явган хүний замыг нэмж өгсөн. Гүүрээр зөвхөн машинаар зогсохгүй хүн, мал, амьтад дамжин өнгөрнө. Хэрвээ гүүрийг өргөсгөхгүй явган замгүйгээр төлөвлөх тохиолдолд явган зорчигчдын аюул осолгүй зорчих нөхцөл хангагдахгүй. Тиймээс явган хүний зам болон зорчих хэсгийг тусгаарлах нь аваар ослоос урьдчилан сэргийлэх зөв шийдвэр юм. Түүнчлэн, хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслээс явган зорчигчийг хамгаалахын тулд бетонон хамгаалалтын ханыг төлөвлөсөн.



3. Гүүрийн хийцийн судалгаа

Гүүрийн хийцийн сонголт

Үндсэн чиг	Судалгааны агуулга
Газар зүйн онцлог	• Тус орон нутагт олдоц ихтэй материалд түшиглэж хийх гүүрний хийц • Тухайн орон нутгийн компаниар гүйцэтгүүлэх боломжтой гүүр төлөвлөх
Түр гүүрийн байршлын төлөв байдал	• Арматур зангидан түр гүүр байгуулахад хүндрэл гарахгүй хийцтэй гүүр • Гүүр байгуулах явцад доод зорчих хэсэгт хөдөлгөөн саадгүй нэвтрэх гүүрний хийц • Гүүрэн доорх голд харшлахгүй байх хийц
Байгууламжийн аюулгүй байдал	•Удаан эдэлгээтэй, салхинд тэсвэртэй гэх мэт байгууламжийн онцлог болон хэт халуун бүс нутаг учраас халууны нөлөөлөл бага авах гүүрийг төлөвлөх • суулт, чичиргээ болон дуу чимээтэйг багасган хөдөлгөөний аюулгүй байдлыг давхар хамгаалсан гүүрний төлөвлөх
Засвар үйлчилгээ	• Эргэн тойрны ууланд түр байршуулж, засвар үйлчилгээний зардал болон сэргээн засварлахад хялбар, бэхжүүлсэн хийцтэй
Гүйцэтгэлийн хувьд	• Кран түр суурилуулах болон тулгуур багана байрлуулах гэх мэт гүйцэтгэлийн аргыг харьцуулан судалж, гүйцэтгэлийг тодорхой, энгийн хийцтэй төлөвлөх
Эдийн засгийн хувьд	• Дээд, доод байгууламжийг нэгтгэсэн ажлын зардал зэрэг нь анхан шатны зардлаас гадна цаашид засвар үйлчилгээний зардал зэргийг харгалзан эдийн засгийн хэмнэлттэй гүүрийн хийц
Дүгнэлт	• Гүүрийн байгууламжийн барилгажилтийн зардал өндөр, эвдрэл гэмтлийн үед сэргээн засварлах нь төвөгтэй, цаг хугацаа шаардагддаг учир гүүрийг түр байгуулахад тохирсон засвар үйлчилгээ, гүйцэтгэл, хөдөлгөөний чанар болон эдийн засгийн хувьд хэмнэлттэй, байгаль орчинтойгоо зохицсан байгууламжийг бүтээх хэрэгтэй ба дээрх чанаруудыг нэгтгэснийг харгалзан үзэж гүүрийн хийцийг төлөвлөсөн болно.

Гүүрний хийцийн харьцуулалт

А) Зорчих хэсгийн хийц

Ангилал	- 1санал (Үргэлжилсэн хавтант дам нуруутай төмөр бетон гүүр) (4@15=60.0)	2санал (PSC Beam гүүр) (2@30.0=60.0)	3санал (RC T хэлбэрийн гүүр) (15.0+15.0+15.0+15.0=60.0)
Дагуу огтлолын зураг			
Хөндлөн огтлолын зураг			

Давуу ба сул тал	- Гүүрийн дам нуруу 0,88 метр учраас гүүрийн доод хэсгийн чөлөөт зайг өргөтгөж болно. - Гүүрийн нийт хэсэг дундаа тасраагүй үргэлжилсэн ба хэв гажилтын заадас цөөн тул авто машин зорчиход ямар нэгэн саадгүй. Мөн үүнээс үүдсэн гарах эвдрэл багатай. - Хэв гажилтын заадас болон гүүрийн тулгуур цөөн учраас (хэв гажилтын заадас 2, гүүрийн тулгуур 12) гүүрийн засвар арчилгаанд хүндрэл байхгүй. - Хэв гажилтын заадас 2 байгаа тул авто машин зорчиход хүндрэлгүй. - Түр тулаас ашиглан гүүрийн дээд хэсгийн барилгын ажлыг гүйцэтгэх бөгөөд барилгын ажлын явцад саад учрахгүй.	- 1 гүүрийн тулгууртай учраас голын усны урсацад ямар нэгэн саадгүй. Гэвч гүүрийн дам нурууны өргөн 2,32м тул гүүрийн доод хэсгийн чөлөөт зайг нэмэгдүүлэх боломжгүй. - Гүүрийн нийт хэсэг дундаа тасраагүй үргэлжилсэн ба хэв гажилтын заадас цөөн тул авто машин зорчиход ямар нэгэн саадгүй. Мөн үүнээс үүдсэн гарах эвдрэл багатай. - Хэв гажилтын заадас болон тулгуур ихтэй тул (хэв гажилтын заадас 2, гүүрийн тулгуур 24) засвар арчилгаа багагүй шаардагдана. - Хэв гажилтын заадас 2 байгаа тул авто машин зорчиход хүндрэлгүй. - Дам нуруу жин ихтэй тул хүнд даацын кран ашиглах шаардлагатай бөгөөд барилга угсралтын ажилд хүндрэлтэй.	- Гүүрийн дам нуруу 1,395 метрийн өргөнтэй учраас гүүрийн доод хэсгийн чөлөөт зайг өргөтгөх боломжтой. - 15 метрийн алгасал бүхий хэв гажилтын заадас ихтэй учраас авто машины явалтаас шалтгаалсан эвдрэл их гарна. - Хэв гажилтын заадас болон гүүрийн тулгуур ихтэй (хэв гажилтын заадас 5, гүүрийн тулгуур 64) учраас засвар арчилгаа ихээхэн шаардагдана. - Хэв гажилтын заадас 5 байгаа тул авто машин зорчиход ихээхэн бэрхшээлтэй. - Хувилбар 2-тай харьцуулахад дам нуруу хөнгөн жинтэй, бага оврын кран ашиглан барилгын ажлыг саадгүй явуулах боломжтой.
Судалганы дараах санал	Гүүрийн нийт хэсэг үргэлжилсэн байдалтай, засвар арчилгаа болон гүүрээр зорчих авто машинд саадгүй, барилга угсралт зэргийг дүгнэвэл хувилбар 1-ийг сонгов.		
Дэвшүүлж буй санал			

Б) Зорчих хэсгийн гүйцэтгэлийн арга

Ангилал	**Тулгуур багана суурилуулалт**	**Bent суурилуулалт**
Байгууламж		
	• RC SLAB, RC Box гэх мэт бага оврын байгууламжинд тохиромжтой • гүүрний доод зайд саадгүй байх тохиромжтой	• Steel box гэх мэт дунд болон том оврын байгууламжинд тохиромжтой • Доод зам болон гүүрний зайд саадтай байгаа үед тохиромжтой.
Давуу сул тал	• Зардал бага • бага оврын тоног төхөөрөмж ашиглан түр байгууламж барихад тохиромжтой • гүүрний доод зайг ашиглах боломжгүй • гүйцэтгэх туршлага хангалттай	• Зардал өндөр • гүүрний доод зайг ашиглах боломжтой • Bent суурь хэрэгтэй • метал хийцийн нийлүүлэлтийн хувьд хүндрэлтэй
Дүгнэлт	• Гүүрний доод хэсэгт зам байхгүй учраас эдийн засгийн хэмнэлттэй гүйцэтгэхэд тохиромжтой тул тулгуур багана суурилуулалах нь ашигтай.	
Сонголт	•	

В) Завсрын тулгуурын харьцуулалт

Ангилал	Хувилбар 1 Ганц маягийн захын тулгуур	Хувилбар 2 Хана маягийн захын тулгуур	Тайлбар
Огтлол			
Давуу болон сул тал	- Голын урсгалын чиглэлийг өөрчилсөн ч урсгалд асуудал үүсэхгүй - Бетоны орцыг хэмнэх боломжтой	- Голын урсгалын чиглэлийг өөрчлөхөд урсгалд асуудалтай - Бетоны орц их	
Судалгаагаар гарсан санал	Голын урсгалын чиглэлийг өөрчилсөн ч урсгалд асуудал үүсэхгүй ба бетоны орцыг хэмнэх ба гүүрийн завсрын тулгуураар эхний хувилбарыг санал болгож сонгосон.		
Дэвшүүлж буй санал	•		

Г) Суурийн хэлбэрийн харцуулалт

Ангилал	Хувилбар 1 Шууд суурь 1	Хувилбар 2 Шууд суурь 2	Хувилбар 3 Шонт гадас суурь (төмөр хоолой)	Хувилбар 4 Шонт гадас суурь (Бетон)
Огтлол зураг				
Давуу тал	- Барилгын ажил хялбар - Хатуу хөрс нь газрын гадаргуутай ойр байх тусам барилгын ажлын зардалд хэмнэлттэй	- Барилгын ажил хялбар - Суурийн гадаргуун хэмжээг тохируулсанаар нэгж хэмээнд ноогдох хүчдэлийн газрын гадаргуунд өгөгдөх газар хөдлөлтийн хэмжээг багасгах боломжтой. Мөн газрын гадаргуун суултыг багасгана. - Зардал боломжийн	- Төмөр материалаархийгдсэн, уртрагт үүсэх агшилт суналтанд үүсэх эсэргүүцэлд хамгийн сайн тэсвэртэй. - Төмөр хоолой учраас бетон шонт гадасын хувьд барилгын ажлын хугацаа богино.	- Төмөр хоолойтой харьцуулхад барилгын ажлын зардал боломжийн - Өргөрөгийн хувьд хамгийн тохиромжой
Сул тал	- Суурийн тулгуурийн хэмжээ бага ба тус гүүртэй адил газар	- Суурийн хэмжээ өргөссөнөөр ухмалын хэмжээ	-Барилгын ажил хүндрэлтэй -Шонт гадасны уртрагт үүсэх	-Бетонон материал учраас уртрагт үүсэх агшилт суналтын тэсвэрлэлт муу

	хөдлөлт тэсвэрлэлт муу газарт оновчтой сонголт бус юм - Газрын гадаргуу муу тул суурь суух аюултай бөгөөд үүнээс үүдэн дээд хэсгийн бүтээцэд аюул үүсэх магадлалтай - Газар хөдлөлтийн үед завсрын тулгурууд нурах аюултай - Тус гүүрийн хувьд оновчтой бус санал	ихсэх	эсэргүүцэлийг тэсвэрлэхийн тулд маш олон тооны шонт гадас хэрэгтэй юм -Зардал өндөр	-Төмөр шонт гадастай харьцуулхад барилгын ажлын хугацаа их шаардах -Тус гүүртэй адил шонт гадасны суурьлуулахад уртрагын хувьд өргөн, хөрсны хуьвд даац муутай учраас оновчтой сонголт бус юм
Судалгааг аар гарсан санал	Тус гүүрийн хувьд, хөрсний даац болон эсэргүүцэх яадвар муу тул хувилбар 1 болон 4 нь оновчтой бус сонголт юм. Төмөр хоолойн шонт тулгуурийг ашиглах тохиолдолд, суурийн хэмжээг багасгаж ухмалын хэмжээг мөн багасгах боломжтой ба шонт гадасны барилгын зардал нь маш өрдөр тусч байна. Шууд суурийг ашиглах тохиорлдолд, суурийн суултыг багасгахын тулд суурийн хэмжээ өргөсөх сул тал байгаа боловч барилгын ажил хялбар, шонт тулгуурт суурьтай харьцуулхад зардалын хувьд боломжийн бүх талын үзүүлэлтээрээ бидний болзолийг хангаж буй тул хувилбар 2-ийг санал дувшүүлж байна.			
Дэвшүүлж буй санал		○		

▶ Гүүрийн суурын бүтээц болон гүйцэтгэх арга аргачлал

Хувилбар.1 Шууд суурь (Ухмал)	 - Гүйцэтгэлийн үед далан босгож, ус дүүргэлтээс хамгаалах үерийн ус чиглүүлэгч даланг суурьлуулж бороотой үед элс шороо урсалтаас хамгаалах - Бороотой үед дотогш ус урсан дүүрэх үед насосоор усыг гадагшлуулах - Ухмалын хэмжээ их ч , гүйцэтгэлийн ажил хялбар төсөвт зардал боломжийн
Хувилбар.2 Шонт гадас суурь (Төмөр шон)	 - Гүйцэтгэлийн үед далан босгож, ус дүүргэлтээс хамгаалах үерийн ус чиглүүлэгч даланг суурьлуулж бороотой үед элс шороо урсалтаас хамгаалах - Газрын нөхцөл байдал гологдолтой шонт гадасны тоо ширхэг ихсэх - Ухмалын хэмжээ энгийн, гүйцэтгэл хэцүү хүнд ба төсөвт зардал өндөр
Хувилбар.3 Шууд суурь (шпунтэн шон)	 - Гүйцэтгэлийн үед далан босгож, ус дүүргэлтээс хамгаалах үерийн ус чиглүүлэгч даланг суурьлуулж бороотой үед элс шороо урсалтаас хамгаалах - Штунтэн шон суурьлуулсанаар хамгаалалт дээд зэрэг - Ухмалын хэмжээ боломжийн боловч ажлын гүйцэтгэл хүнд, төсөвт өртөг өндөр
Судалгааны дүнд дэвшүүлж буй санал	Хийцийн хувьд хялбар тохиромжой, бүтээцийн хувьд бат бэх, төсөвт өртөг харьцангуй боломжийн тул Хувилбар -1-ийг тохиромтой гэж үзэн санал болгож байна.

4. Гүүрийн хэлбэрийн төлөвлөлт

1) Гүүрний гадаргууны усны хамгаалалтын харьцуулалт

Ангилал	Усны хамгаалалтын түрхэлтийн арга	Усны хамгаалалтын хавтсан арга
зураг		
Товчлол	• гол төлөв ASPHALT-ыг нийлэг резинээр чанарыг сайжруулан гүүрний хавтанд ашигладаг, ажлын арга болон тогтмол хэмээ хадгалах материал байдаг.	• нэхмэл болон нэхмэл бус эдлэлийг хайлуулж гаргасан резины нэгдэл АР-ыг бүрсэн хавтас /sheet/-ыг наалдуулж хэрэглэдэг АР, мөн хайлуулан гүүрний хавтан дээр наалдуулснаар ус нэвчихээс хамгаалж хагарал үүсэхээс сэргийлсэн бөгөөд чичиргээнд тэсвэрлэх чанарыг нэмэгдүүлэх арга юм
Онцлог	• чичиргээ болон шинээр барихад уян хатан чанар нь дээд зэрэг • ус болон халуунд тэсвэрлэх чанар дээд зэрэг • Шалны хавтан нь ан цав үүссэн нь ч тэсвэрлэх чадвартай • хавтан болон хучилтын наалдамхай чанар сайн • залгаасгүй усны хамгаалалтын давхаргыг хийх боломжтой • ажлын зардал бага зэрэг өндөр	• уснаас хамгаалах үр дүн болон ажил гүйцэтгэх чадварын хувьд давхар хамгаалалттай • цууралтын хувьд усны хамгаалах чадвар давхар хамгаалалттай. • түрхэлтийн зузааныг тогтоох болон хурдан хийх боломжтой • ус зайлуулах хоолой гэх мэт ажлыг дуусгах үед нарийвчилсан гүйцэтгэл хийх шаардлагатай. • төмөр болон хальст давхаргад усны хамгаалалт хийх тохиромжгүй • зардал өндөр
Дүгнэлт	• ажлын гүйцэтгэл, засвар үйлчилгээ, усны хамгаалалт хийх болон эдийн засгийн хэмнэлттэй, давхар хамгаалалттай түрхэлтийн усны хамгаалалтыг ашиглах.	
Сонголт	•	

2) Хашлага болон хамгаалалтын хана

◦ хөдөлгөөний ачаалал эрс нэмэгдэж байгаатай холбогдон гүүрэн дээр авто осол гарах нь ихсэж байгаа нь үнэн болно. Ялангуяа гүүрэн дээрээс машин унах осол нэмэгдэж байгаа учир энэ тал дээр арга хэмжээ авахын тулд жолоочийн аюулгүй байдлыг хангах саналтай байна.

Ангилал	**Бетонон хамгаалалтын хашилт**	**өндөр даралт бүхий хөнгөнцагаан хамгаалалтын хашилт**
Хэлбэр		
Сул давуу тал	• өнгө үзэмж муутай - Зардал багатай - үзэмж муутай - засвар үйлчилгээ нэн шаардлагатай	* үзэмж сайтай • зардал өндөр • Материал нийлүүлэлт бэрхшээлтэй • Засвар үйлчилгээ шаардлагатай
Сонгосон шалтгаан	• засвар үйлчилгээ болон эдийн засгийн хэмнэлттэй байдлыг үндэслэн автомашин унахаас хамгаалсан бетонон хашилтаар гүйцэтгэх	
Сонголт	•	

ГҮҮРИЙН УГААГДАЛТЫН ТООЦОО

5. Гүүр төлөвлөлт

5.1 Зураг төслийн норм дүрэм

Энэхүү гүүрийн зураг төслийг Монгол улсын зураг төслийн норм дүрмийн дагуу гүйцэтгэсэн. Гэвч зураг төслийн норм дүрэм тодорхой бус эсвэл дутуу байгаа тохиолдолд ерөнхий инженерийн шийдвэрийн дагуу гадаадын холбогдох норм дүрмийг ашигласан болно.

Ашигласан норм дүрэм дүрмүүд

- БНбД 32.02.03(2005) – Монгол
- AASHTO LRFD Bridge Design Specifications(4th Edition 2007) – USA
- Зам гүүрийн зураг төслийн норм дүрэм (2010) – БНСУ
- Зам гүүрийн зураг төслийн норм дүрмийн тайлбар (2008) – БНСУ

5.2 Ачаалал

5.2.1 Тогтмол ачаалал

1) Хувийн жин

Ангилал	Хувийн жин(хүндийн жин)	Тайлбар
Бетон	2320kg/m^3	AASHTO LRFD-3.5.1
Төмөр	7850 kg/m^3	AASHTO LRFD-3.5.1
Хөрс	2000 kN/m^3	Korea Standard
Асфальт бетон	2250 kg/m^3	AASHTO LRFD-3.5.1

- Төмөр бетоны хувьд бетоны нэгж жинд 72kg/m3-ыг нэмж ашиглана. (AASHTO LRFD-C3.5.1)
- Хөрсний хувийн жинг Монгол улсын зураг төслийн норм дүрэмд 1.7TH/m3 гэж заасан байдаг.(БНбД 32.02.03-2.6). Гэхдээ энэ нь энгийн хөрсний жин юм. Гүүрийн захын тулгуурын ард талд дүүргэж байгаа шороо суурийн доод үе учраас хангалттай хэмжээнд нягтруулах шаардлагатайг харгалзан хувийн жинг аюулгүй талаас нь тооцоолно. Тиймээс хөрсний хувийн жинг тооцохдоо БНСУ-ын норм дүрэм (зам гүүрийн зураг төслийн норм дүрмийн тайлбар (2008)-хүснэгт 2.1.3)-ийг ашиглав.
- Бүтээцийн хувийн жин нь дээр дурдсан хувийн жинг хүндийн хүчний хурдатгалд үржүүлж ачаалал (kN/m^3)-ыг гаргаж тооцно.

2) Хөрсний даралт

Гүүрийн захын тулгуурт хэвтээ чиглэл дагуу үйлчилж буй хөрсний даралтыг тодорхойлохдоо хөрсний хувийн жинд хөрсний даралтын коэффициентыг үржүүлэн тооцно.

Монгол улсын зураг төслийн норм дүрмийн (БНбД 32.02.03-2.6) дагуу хөрсний даралтын коэффициентыг дараах томъёогоор тодорхойлно.

$$\tau_n = tg^2(45^\circ - \frac{\varphi}{2})$$

үүнд, φ = хөрсний дотоод үрэлтийн өнцөг

Гүүрийн захын тулгуурын ард талд дүүргэх шороог сайтар нягтруулах шаардлагатай бөгөөд үүнтэй холбогдуулан дотоод үрэлтийн өнцгийг 35°-аар бодож гаргасан.

3) Бетоны агшилт ба гулсалтын үйлчлэл

Монгол улсын зураг төслийн норм дүрэм (БНбД 32.02.03-3.15)-ийн дагуу дараахтай адил тооцоолно.

$\Delta\sigma_p(t) = (1 - e^{-\lambda t})$ $\Delta\sigma_p(t \to \infty)$

Үүнд, t = бетон цулгалт дууссан үеэс эхлэн агшилт, гулсалтын үйлчлэл бүрэн дуусах үе.

e = 2.718(natural logarithms)

Агаарын чийгшил 40 хувиас доош байхаар тооцож байгаа тул бетон агшилт 25 хувиар нэмэгдэнэ.

4) Суурийн шилжилтийн ачаалал

Хөрсний суултаас шалтгаалан гүүрийн захын тулгуурын сууринд үүсэх суултыг тооцоолох хэрэгтэй. Суултын хэмжээг БНСУ-ын зураг төслийн норм дүрэмд үндэслэн 10мм-ээр тооцов.

5.2.2 Түр ачаалал

1) Авто машины нэг тэнхлэг дээрх ачаалал

Монгол улсын зураг төслийн норм дүрэм(БНбД 32.02.03-2.11)-д заасан А11 ачаалал, NK-80 ачааллыг судална. Түүнчлэн AASHTO-д тусгасан HS20 ачааллыг давхар судална. Монгол улсын норм дүрэм болон AASHTO норм дүрмээс хамгийн хүнд ачааллыг өгч тооцно.

<table>
<tr><td colspan="2">Монгол улсын зураг төслийн норм дүрэм(БНбД 32.02.03-2.11)</td></tr>
<tr><td>А11 ачаалал(Монгол)</td><td>NK-80 ачаалал(Монгол)</td></tr>
<tr><td> 
</td><td> 
</td></tr>
<tr><td colspan="2">AASHTO - 3.6.1.2</td></tr>
<tr><td> 
</td><td> 
</td></tr>
</table>

Дээрх хоёр төрлийн автомашины нэг тэнхлэг дээрх ачааллыг харьцуулж хамгийн хүнд ачааллын талаарх бүтээцийн тооцоог хийнэ.

2) Автомашины нэг тэнхлэг дээрх ачааллын чадлын коэффициент

Монгол улсын зураг төслийн норм дүрэм (БНбД 32.02.03-2.17)-ийн дагуу дараах томъёогоор тодорхойлно.

$$1+\mu=1+\left[\frac{45\ \lambda}{135}\right]$$

Үүнд, λ = ачааллын тархалт (=15m)

Үүнтэй адил тооцоологдсон коэффициентыг авто машины нэг тэнхлэг дээрх ачаалалд нэмж ашиглана.

Хэв гажилтын заадас, тулах цэгийн зураг төслийг гүйцэтгэхэд 2.0-ын дагуу хийнэ.

3) Цохилтын динамик ачаалал

Монгол улсын зураг төслийн норм дүрэм (БНбД 32.02.03-2.14)-ийн дагуу дараахтай адил тооцоолно.

11.8 kN-ын ачааллыг бетонон хашлагын 2/3 хэсэгт хэвтээ чиглэлд үйлчлүүлнэ.

4) Төвөөс зугтах хүчний ачаалал

Тус гүүр авто замын трассын шулуун хэсэгт байрладаг учир хамааралгүй болно.

5) Явган хүний замын ачаалал

Монгол улсын зураг төслийн норм дүрэм (БНбД 32.02.03-2.16)-ийн дагуу дараах томъёогоор тодорхойлно.

$$p = 3.92 - 0.019\lambda > 1.96 \text{ kPa}$$

Үүнд, λ = ачааллын тархалт (=15m)

Гүүрийн хоёр талд 1.5 метрийн өргөнд жигд ачааллаар үйлчилнэ.

5.2.3 Бусад ачаалал

1) Салхины ачаалал

Монгол улсын зураг төслийн норм дүрэм(БНбД 32.02.03-2.20)-ийн дагуу дараах томъёогоор тодорхойлно.

$$w_N = q_0 k_n C_w$$

Үүнд, w_N = хөндлөн чиглэлд салхины норматив эрчим > 1.77 kPa

k_n = 1.45

C_w = агаарын хавиралцлын итгэлцүүр (aerodynamic factor)-ийг ашиглан хүснэгт 9-д заасны дагуу 1.75 хэрэглэх

q_0 = газрын гадаргаас дээш 10 метрийн төвшин дэх салхины даралт.

Оросын норм дүрэм SNiP 2.02.07-85-д заасан 0.85kPa-ыг ашиглана.

Дээр дурдсан ачаалал гүүрийн хажуу талд хэвтээ чиглэл дагуу үйлчилнэ.

2) Усны даралт

Монгол улсын зураг төслийн норм дүрэм (БНбД 32.02.03 хавсралт-7)-ийн дагуу дараахтай адил тооцож бодно.

$P = K / V^2 = 0.0932$ (TH/m^2) =0.932kPa

Үүнд, V = усны урсгалын хурд (m/s)-аар усны тооцоонд үндэслэн 3.84m/s ашиглах

K = 1.375 ашиглах (голын усны урсгалын чиглэлтэй перпендикуляр)

Дээрх ачаалал гүүрийн тулгуур баганын усанд автаж буй хэсэгт хэвтээ чиглэл дагуу үйлчилнэ.

3) Мөсний ачаалал (Ice floe)

Монгол улсын зураг төслийн норм дүрэм (БНбД 32.02.03- хавсралт 7)-д үндэслэн мөсний гүүрийн тулгуурт үзүүлж буй ачааллыг тооцоолох ёстой. Монгол улсын зураг төслийн норм дүрэмд заасан мөсний ачаалал ба үйлчлэлүүдийг тооцдог томъёо AASHTO 3.9.2.2-ын томъёотой адилхан.

AASHTO норм дүрэм нь том хэмжээний мөс гүүрийн тулгуурт доргилт учруулж үүний улмаас үүсэх эвдрэлийг тооцоолдог томъёо юм. Уг норм нормативын тайлбарт үндэслэвэл 60 метр хэмжээтэй мөс гүүрийн тулгуурт доргилт учруулахад эвдрэл үүсч болохоор тооцоологдож байна.

Гүүр баригдах газар нутагт байдаг гол ердийн үедээ 20 метр хүртэлх өргөнтэй, гүехэн учраас дээрхтэй ижил доргилтоос үүсэх мөсний ачаалал үүсэхгүй гэж дүгнэж байна.

4) Температурын ачаалал

Монгол улсын зураг төслийн норм дүрэм (БНбД 32.02.03-2.22)-ийн дагуу дараах томъёогоор тодорхойлно.

- Хэв гажилтын зориулалтын холбоос /expansion equipment/, гүүрийн тулах цэгийн шилжилт хөдөлгөөнийг тодорхойлохдоо

T = -50℃ ~ 40℃

- Дээд хэсгийн бүтээцийн дээд болон доод талын температурын зөрүү 10℃ байна.

5) Газар хөдлөлтийн ачаалал ба үйлчлэлүүд

Гүүр байрлах бүс нутаг газар хөдлөлийн 6 баллд хамаарагдах тул БНбД 32.02.03-1.1 –ийн дагуу газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын зураг төслийг хассан.

5.3 Ачаалалын хослол

Монгол улсын авто замын зураг төслийн норм дүрэм (БНбД 32.02.03- Хавсралт2)-ийн гаргалгаагаар ачаалал тус бүрийг нэгтгэн гүүрийн бүтээцийг судласан.

5.4 Ашиглах материал

5.4.1 Арматур

Төрөл	Эсэргүүцэлд муу хүчдэл (Yield strength)	Уян харимхайн коэффицент (Elastic Modulus)	Хүндийн нэгж (Unit Weight)
SD30	Fy=300Mpa	Es=200,000Mpa	78.5kN/m^3
SD40	Fy=400Mpa		

5.4.2 Бетон

Бетон дүүргэгч материалын хамгийн их ширхэглэлийн хэмжээ(mm)	Fck Шахалтын хүчдэл (Mpa)	Slump Суулт (cm)	БНбД 32.02.03-т өгөгдсөн беттоны задаргаа	Ашиглагдах хэсгүүд
25	27	15	B45	Хавтан болон завсрын тулгуур
30	24	15	B40	Захын тулгуур
40	18	8	B25	Далан хамгаалалтын блок суурь
40	15	8	B20	Бусад
Агшилтгүй зуурмаг (1:1)				Гүүрийн тулц

Тус төсөлд ашигласан бетоны нягтралын хүчдэл нь AASHTO LRFD Bridge Consturction Specifications-ний Section 8 буюу цилиндр хэлбэрийг ашиглан туршилт хийж дүгнэсэн.

Монгол улсын норм дүрэм нь 150 x 150 x 150mm^3 –ийн хэмжээтэй туршилтийн сорьцийн дүгнэлтээр суурийн бетоны зэрэглэлийг тогтоож тус зураг төсөлтэй бага зэргийн ялгаатай байна. Eurocode 2 нь хоёр төрлийн аргаар бетоныг ялгадаг. Үүнийг харьцуулахад Fck=27Mpa нь B45 бетоны зэрэглэлтэй, Fck=24Mpa нь B40 зэрэглэлтэй дүйцэж байна. Мөн бетоны нягтралын хүчдэлийг нэмэгдүүлэхийн тулд талбайд туршилт заавал хийж шалгах шаардлагатай.

Төмөр бетоны чанар нь бетоны цутгах үеийн нягтралшилтай уялдуулан арматур болон бетоныг нэг биет болгох шаардлагатай.

Энэ нь бетоны ажлын гүйцэтгэлтэй холбоотой ба энэ нь конусын суултын үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ. Конусын суулт нь хэт илүүдсэн тохиолдолд, материалын гологдол болон шингэнийг шахах асуудал үүсэх магадлалтай ба тохиромжит зураг төслийг гүйцэтгэх шаардлагатай.

5.5 Хэрэглэх программ



Программын нэр : RC Bridge

Шинээр бүтээсэн газар : Солонгос

Үүрэг : Гүүрийн хавтан болон гүүрийн гулдан зэргийн хийц бүтээцийн талаар бүтээцийн тооцоо болон зургийн автомат программ.

6. Бэхэлгээ

6.1 Чулуун бэхэлгээ

Зурагт үзүүлсэн юмуу инженерийн зааварласан газарт гүйцэтгэгч ухаж, засаж тэгшлэн чулуун бэхэлгээ хийнэ. Чулуун бэхэлгээг хатуу, бат бөх, ердийн хэлбэртэй чулуугаар хийнэ. Карьерын чулууг ашиглана. Бөөрөнхий хэлбэртэй чулуу ашиглахыг хориглоно. Ус юмуу цаг агаарын нөлөөгөөр элэгдэж өгөршдөг чулууг ашиглахгүй. Хамгийн том хэмжээтэй чулуунуудыг ашиглах бөгөөд Инженер өөрөөр зөвшөөрөөгүй тохиолдолд 45 кг-аас бага жин татах аливаа фрагментыг хэрэглэхгүй. Чулууны хэлтэрхийнүүдийн хамгийн бага зөвшөөрөгдөх хэмжээ 35 мм байх ба бэхэлгээний нүх сүвийг бөглөхөд тохирсон байна. Бэхэлгээний чулууны бэхэлгээнийм хувийн жин нь дор хаяж 2.40 байна.

Чулуун бэхэлгээ хийх хэсгийг ухаж, хэлбэржүүлэн тэгшилж чулуунуудыг тавихад бэлэн болгон 95% хүртэл ХИХН-аар (AASHTO T180) нягтруулна. Бэхэлгээ хийх хажуу налуугийн хормойгийн дагуу юмуу голын голдиролын ёроолын дэвсэгт хийгдсэн бэхэлгээний устай харьцах хэсгийн дагуу шуудуу татна. Шуудууны ёроолоос эхлэн чулуунуудыг байрлуулан хажуу налуу дээр чулуунуудыг хооронд нь сайтар чигжиж суулгаж өгнө. Чулуун бэхэлгээний тогтоосон зузаанаас чулууны хамгийн өргөн тэгш өнцөгтэй тал нь илүү гараагүй л бол тэдгээрийг хажуу налууны ирмэг дээр шигтгэн суулгана. Чулуунуудыг хамгаалалт хийх гадаргуу дээр сайтар чигжиж дагтаршуулж хооронд нь зайгүй болтол нь тааруулан байрлуулах замаар маш бага завсар үлдээх ба тэдгээрийг тохирох байдлаар нь зорж хэлбэр гарган шаантагласан үртэс чулуугаар чигжиж дүүргэнэ. Бэхэлгээний дээд хэсгийг залгаа үетэй хамт тэгшилнэ.

Цементэн зуурмаг хийхээр заагдсан газруудад чулууны гадаргууг сайтар цэвэрлэж, наалдсан хог, шавраас нь салгана. Ус зайлуулах нүх болгон 20%-ийн босоо заадас үлдээнэ гэж инженер зааварласан гэж тооцон бүх нүх сүвийг нийтэд нь бөглөх үүднээс 1:3 цемент, элсний харьцаагаар бэлтгэгдсэн цементэн зуурмагийг чулуунуудын хоорондох зай завсраар чигжиж шавна. Цементэн зуурмагийг бэхэлгээ хийсэн гадаргуутай хамт тэгшилж багсаар сайтар шүүрдэж цэвэрлэн дээд талын хэсгийг ил гаргана. Цементэн бэхэлгээг нойтон шуудайгаар хучиж юмуу эсвэл зөвшөөрөгдсөн

аргаар бэхжүүлэх замаар цементэн зуурмагаар бэхэлгээ хийсний дараа долоогоос багагүй хоногийн турш цаг агаарын нөлөөнд автахаас хамгаалах арга хэмжээ авна.
Бэлэн болсон налуу юмуу чулуун бэхэлгээг хийхийн өмнө гадаргуу дээр чулуун бэхэлгээний нүх сувээр дамжин далангийн шүлтгүйжилт үүсэхээс сэргийлэх, бэхэлгээн дээр хөрсний овойлт үүсгэлгүйгээр усыг чөлөөтэй урсгах боломжийг хангах үүднээс шүүрүүлэх үеийг тавина. Чулуун бэхэлгээний дор тогтоосон зузаан бүхий нэг үе тэгшилсэн шүүрүүлэх үеийг хангана. Шүүрүүлэх орчинд орох агрегат нь AASHTO авто зам барих удирдамж техникийн шаардлагын бүлэг 700-н шаардлагуудыг хангах ёстой.

6.2 Чулуун рисберм:

Рисбермд ашигласан чулуу нь хатуу, бат бөх, ердийн хэлбэртэй чулуу байна. Ус, цаг агаарын нөлөөгөөр элэгдэж өгөршдөг чулууг ашиглахгүй. Бөөрөнхий хэлбэртэй чулуунаас илүү өнцөг хэлбэртэй чулуу ашиглана. Чулууны хэмжээ зурагт заагдсан юмуу эсвэл инженерийн зөвшөөрсний дагуу байна. Рисбермийг дэвсэх гадаргууг зурагт заасан өргөн уртад тэгшилж бэлтгэнэ.

6.3 Чулуун асгаас

Чулуун асгаас нь хатуу, бат бөх, буталсан, карьераас олзворлосон юмуу байгалийн чулуун агрегатаас бүрдэнэ. Дор хаяж 75мм зузаан, хамгийн бага нь 23кг-ын жинтэй байх чулууны дор хаяж 60 хувь нь 35кг-аас илүү масстай байх ба чулуун асгаасны жигд тархалтыг хангах үүднээс чулуунуудын хооронд шаантаглаж чигжихэд тохирох хэмжээтэй фрагмент юмуу хэлтэрхийнүүдийг агуулсан байна. Чулуун асгаасны хувийн жин нь дор хаяж 2.40 байна.
Чулуун асгаас дэвсэх гадаргууг хэлбэржүүлэн тэгшилж 95% хүртэл ХИХН-аар (AASHTO T180) нягтруулна. Чулуун асгаасыг 600мм гүнд чулуун асгаасны тогтоосон өндөртэй шуудуунд баригдсан 1м өргөн хуурай чулуун өрлөг ханаар бэхэлнэ.
Инженерийн зааварласан, зурагт үзүүлсэн хэсэгт нэг эсвэл хоёр үе ширхэглэлийн бүрэлдэхүүнээр сонгосон нэвчүүлэх материалуудаас бүрдсэн шүүрүүлэгч материалыг бэлтгэсэн гадаргуу дээр шаардагдах зузаантайгаар дэвсэж дэвссэн үе бүрийг тэгшилж засна. Уг ширхэглэл бүхий шүүрүүлэх материалыг ширхэглэлийн бүрэлдэхүүнээр сонгох шаардлага нь техникийн шаардлагын зүйл 707-ын шаардлагад нийцсэн юмуу инженерийн зааварласны дагуу байна.
Чулуунуудыг далангийн налуугийн ёроолоос эсвэл газрын хөрснөөс дээш том чулуунуудыг доод хэсэгт нь тавих тавих байдлаар хооронд нь маш ойрхон чигжиж байрлуулна. Тэгш, дагтаршуулсан гадаргуу барих үүднээс сайтар чихэн дүүргэж тохиромжтой үртэс чулуунуудаар шаантаглан чигжинэ.

7. Гүүрийн аюулгүй байдлыг шалгах

Газрын давхаргын одоогийн байдал



Гүүрийн суурь нь давхрагын үе болон угаагдлын судалгааны дүгнэлтээс шалтгаалан шийдвэрлэнэ. Судалгаанаас үзвэл угаагдлын гүн нь газрын гүнээс эхлэн 2.8м. Тиймээс завсрын тулгуурын суурь нь угаагдалтын гүнээс доошоо байрлуулахаар төлөвлөсөн.

Хөрсны давхрагын үе нь $apQ_{3\text{-}4\ д}$ үе болох чийгтэйгээс усаар ханасан элсэн чигжээстэй сайр байхад, R_3 үе нь хатуулаг элсэн чулуутай байсан учир гүүрийн суурийг суулгахад боломжит хөрс гэж үзсэн.

R_3 үе нь хөрсний шинжилгээний дүгнэлтээр 47ton/m^2 дээш байхаар илэрсэн. Гүүрийн бүтээцийн дүгнэлтээр суурьт өгөгдөх хамгийн их даацын хэмжээ нь 31ton/m^2 ба суурийн хөрсийг боломжтой гэж үзсэн.

Гүүрийн суурийн гүн нь угаагдлын гүн, хөрсны судалгааны дүгнэлт, даац зэргийг хамтатган үзэж дүгнэлт хийсэн. Мөн гүүрийн барилгын ажлын үед хөрсний давхрагын хүчдэлийн туршилтийг хэрэгжүүлж зураг төсөлд өгөгдсөн даацын хамгийн их хэмжээг заавал шалгах шаардлагатай.

Ангилал		
1	ИГЭ No1	Элсэн чигжээстэй сайр сайрган хөрс
2	ИГЭ No2	Элсэн чулуу

Ангилал		Mechanical Characteristics			R0 kPa	Calculated Value			
		CH kPa	dH degree	EH MPa		C'	C"	d'	d"
						kPa		Degree	
1	ИГЭ No1	2	40	45	600	2.7	4	39	41

1 газрын давхаргын тулах хүч 600kPa бөгөөд уян харимхайн коаффицентийн хэмжээ 35MPa дээш хангалттай бат бэх болсноор үүнийг гүүрийн суурийн тулах хэсгээр сонгон авч байна.

ИНЖЕНЕР - ГЕОЛОГИЙН ЗҮСЭЛТ /ШАРГАЛЖУУТ ГОЛ/



Цооногийн дугаар	Ц-1		Ц-2
Амсрын өндөржилт, м	1880.76		1881.20
Цооног хоорондын зай, м		40.0 м	

Таних тэмдэг

ap Q_{3-4} ① Бор саарал өнгөтэй, чийгтэйгээс усаар ханасан элсэн чигжээстэй сайр, сайрган хөрс. Бул чулуу ихээр агуулсан

R_3 ② Ягаандуу, цайвархаарал өнгөтэй, элсэн чулуу

① Инженер-геологийн элементийн дугаар

ap Q_{3-4} Хөрсний нас, гарал үүслийн тэмдэглэгээ

Цооногийн амсар

Эвдэрсэн бүтэцтэй дээж авсан гүн, м

Чулуулгийн дээж авсан гүн, м

4.2 Хөрсний үеийн хил зааг

▼1.0 2013.11.02 Хөрсний усны илэрсэн түвшин, м Хэмжилт хийсэн огноо

6.0 Цооногийн гүн, м

Хөрсний төлөв байдал

	Элсэн хөрсөнд
	Чийгтэй
	Усаар ханасан

"Инжгеотех" ХХК	"ИНЖГЕОТЕХ" Х Х К			Үе шат
				А/3
	Захиалагч	"Гео зураглал" ХХК		Зургийн дугаар
	Объект	Баянхонгор - Шаргалжуут чиглэлийн 60 км автозам /ГҮҮР-1/		1
Шалгасан		С.Должин	Зургийн нэр	Масштаб
Зохиосон		Б.Баатарцогт	Инженер-геологийн зүсэлт I - I' шулуунаар	Б 1:100 Х 1:400
Зурсан		Б.Баатарцогт		

8. Ажлын тоо хэмжээ

Зохион байгуулалтын ажил

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Харуул манааны суурин байр байрлуулах	1ш	1
2	Ажиллагсдын байрлах түр байр байгуулах	1ш	4
3	Машин механизмын засварын фокустай талбай байр	1м^2	20
4	Дизель станц байрлуулах	1ш	2
5	Харуул хамгаалалтын, аж ахуйн ажиллагсдын ажил	1 у/м	15

Барилгын талбайн бэлтгэл

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Гүүр барих хэсгийн зурвас газрын цэвэрлэгээ	1м^2	2800
2	Барилгын үйлдвэрлэл явуулах талбай	1м^2	500
3	Мэдээллийн самбар	ш	2

Гүүрийн материалын хийц бүтээцийн үйлдвэрлэлийн бэлтгэл ажил

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Цементийн агуулах байгуулах 50тн	1ш	2
2	Бетон зуурмагийн узель байгуулах	1ком	1
3	Арматур болон төмөр хийц бүтээц боловсруулах төх	1 ком	1
4	Карьер нөхөн сэргээх	1м^2	1000

Ажлын тоо хэмжээ

Ажлын нэр	Хэмжээ	Нэгж	Rhamen	Abut	Чулуун бэхэлгээ	нийт
1 Байгууламж						
1.01 Газар шорооны ажил						
a. Хүнхээл ухах	(100%машин)					
a-1 Хүнхээл ухах шороо	(0-4м)	м3	3083.890	714.682		3799
a-2 Хүнхээл ухах устай шороо	4м дээш	м3	47.569			48
b. Буцаан дүүргэлт ба нягтруулах	(100%машин)	м3	1896.810	538.181		2435
c. ус зайлуулах		hr	145.692			146
d. дахин ашиглах шороо		м3	1234.654	176.501		1411
1.02 Байгууламжийг буцаан дүүргэх	(SB-1)	м3		387.166		387
1.03 Рисберм		м3		94.086		94
1.04 Хэв хашмал						
a. Хэв хашмал/фанер3ш						
a-1 Хэв хашмал/фанер 3ш, Босоо	(0-7м)	м2	279.288	242.452		522
a-2 Хэв хашмал/фанер 3ш, Босоо	(7-10м)	м2	118.840			119
a-3 Хэв хашмал/фанер 3ш, Налуу	(7-10м)	м2	65.859			66
a-4 Хэв хашмал/фанер 3ш, Гадаргуу	(0-7м)	м2	278.177			278
a-5 Хэв хашмал/фанер 3ш, Гадаргуу	(7-10м)	м2	36.537			37
a-6 Хэв хашмал/фанер 3ш, Хэвтээ	(0-7м)	м2	712.810			713
b. Хэв хашмал/фанер 4ш	(0-7м)	м2	113.520	87.896		201
c. Хэв хашмал/фанер 6ш	(0-7м)	м2	10.560	10.454	529.556	551
d. Хэв хашмал (хээтэй) Хэв хашмал						
d-1 Хэв хашмал (хээтэй) Хэв хашмал	(0-7м)	м2		251.207		251
1.05 Барилгын шат						
a. Барилгын шат						
a-1 Барилгын шат	(3сараас бага,0-30м)	м2		415.436		415
b. Тулгуурт шат		м		202.600		203
1.06 Турбан тулаас						
a. Турбан тулаас	(гүүрийн зориулалт)	м3		77.496		77
в. Турбан тулаас	хэвтээ холбогч (3сар)	м3		4.562		5
1.07 Арматур болон бэхэлгээ						
a. Арматур матаж боох	(хялбар)	тн		0.438		0
b. Арматур матаж боох	(энгийн)	тн	6.512	9.316		16
c. Арматур матаж боох	(ажлын)	тн	124.435	33.700		158
d. арматур матаж боох						
d-1 арматур матаж боох	H = 30м бага	тн	130.947	43.454		174

1.08 Бетон цутгалт						
a. Бетон цутгалт (Pump)	(15м бага)	м3	939.397	423.223	172.106	1535
b. Бетон цутгалт	(VIB багтсан)	м3		27.384	693.929	721
c. Бетон зуурмаг	(хольц дутмаг)	м3	19.965			20
1.09 Гадаргуу						
a. Хавтан бетон арчилгаа	(нэмэлт)	м2	658.911			659
b. Хавтан гадаргуу тэгшлэх	DECK FINISHER	м2	658.911			659
1.10 Гадаргуун усны хамгаалт						
a. Гадаргуун усны хамгаалт	(шүршдэг битум)	м2	658.911			659
1.11 Дамжих хавтангийн хэсэг	(D25,L=600мм)	ш		52		52
1.12 Үл агших mortar						
a. Үл агших mortar	(1:1)	м3		0.262		0.262
1.13 Хөөсөнцөр						
a. Хөөсөнцөр	(T=5мм)	м2		8.874		9
b. Хөөсөнцөр	(T=20мм)	м2		4.980		5
1.14 Гүүрийн тулаас						
a. хоёр чиглэл	1000kN, H=161	ш		8.000		8
1.15 SOLE PLATE						
a SOLE PLATE		тн		0.390		0.390
1.16 Дотор усны хамгаалт	(усны хамгаалалт)	м2		295.178		295
1.17 Захын тулгуурын хамгаалт блок						
a чулуун овоолго		м3			4956.636	4956.64
b нарийн хайрга	Dia.>300mm, W>45kg	м3			2299.167	2299
c буцаан дүүргэлт	(хайрга)	м3			495.664	495.66
d зуурмаг	(1:3)	м3			44.609	45
1.18 Зай баригч хийх						
a Зай баригч хийх	(Хана)	м2	593.763	560.888		1155
b Зай баригч хийх	(Хавтан)	м2	902.020	261.986		1164
1.19 NOTCH	(хөнгөн цагаан)	м	119.802			119.802
1.20 Хашлага						
a Хашлага		м	120.000			120
1.21 Тэгшилгээний үе	(RSC-1)	м2	1317.822			1318
1.22 Гүүрийн хучилт	T=80мм	м2	658.911			659
1.23 Материал тээвэрлэлт зардал						
a цемент тээвэрлэлт	(шуудай,40 kg)			6	138	144
b арматур тээвэрлэлт	агуулах -талбай	тн				
c элс тээвэрлэлт		м3		0.277	18.969	19
d хайрга тээвэрлэлт	(φ19мм)	м3				
a цемент	(40kg)			6	138	144
b арматур						

b-1 арматур	H10m/m	тн				
b-2 арматур	H13m/m	тн	24.397			24
b-3 арматур	H16-32m/m	тн	128.960			129
b-4 арматур	D10m/m	тн				
b-5 арматур	D13m/m	тн	3.554	0.887		4
b-6 арматур	D16-32m/m	тн	3.152	58.141		61
c бетон						
c-1 бетон	(19-45-15)	м3				
c-2 бетон	(19-40-15)	м3				
c-3 бетон	(25-27-15)	м3	893.797			894
c-4 бетон	(25-24-15)	м3	45.600	423.223		469
c-5 бетон	(40-15-8)	м3	19.965	27.384		47
c-6 бетон	(40-18-15)	м3			41.586	42
c-7 бетон	(40-15-15)	м3			167.672	168
Тайлбар: Бетон (a-в-c) a- Дайрганы max хэмжээ /мм/, в- шахалтын бат бэх /Мпа/, c- slump буюу бетоны суулт						

Нийт материалын түүвэр

Материалын нэр	Х/Н		Нэгж	Rhamen	Abut	Хамгаалах блок	NET	Хорогдол	Тайлбар
Цемент	Задгай		TON		0.204	5.497	0.204	5.815	2%Хорогдол
	шуудай(40kg/1)		шуудай		6	138	144	146	"
Хайрга	Элс		M^3		0.277	18.969	19.246	12.270	"
Дайрга	Ф 19 m/m		M^3						"
Дайрга	Ф 25 m/m		M^3						"
Арматур	Хүчитгэсэн	H32	TON	12.675			12.675	13.436	6%Хорогдол
		H29	TON	24.669			24.669	26.149	"
		H25	TON	26.496			26.496	28.086	"
		H22	TON	20.41			20.410	21.635	"
		H19	TON	14.814			14.814	15.258	3%Хорогдол
		H16	TON	23.687			23.687	24.398	"
		H13	TON	1.445			1.445	1.488	"
		H10	TON						"

	Дүн		TON	124.196			124.196	130.449	
	Хүчитгээгүй	D32	TON		2.486		2.486	2.635	6%Хорогдол
		D29	TON						"
		D25	TON		15.061		15.061	15.965	"
		D22	TON		1.476		1.476	1.565	"
		D19	TON		8.67		8.670	8.930	3%Хорогдол
		D16	TON	3.060	14.732		17.792	18.326	"
		D13	TON	3.452	1.031		4.483	4.617	"
		D10	TON						"
	Дүн		TON	6.512	43.456		49.968	52.038	
Нийт арматур			TON	130.708	43.456		174.164	182.487	
Зуурмаг	19-45-15		M^3						1%Хорогдол
	19-40-15		M^3						"
	25-27-15		M^3	893.797					"
	25-24-15		M^3	45.600	423.223				"
	40-18-15		M^3			41.586			"
	40-15-15		M^3	19.965	27.384	167.672			2%Хорогдол

Нийт арматурын түүвэр

Материалын төрөл	Х/Н		Нэгж	Rhamen	Abut	Нийт		Тайлбар
						NET	ADD	
Арматур	Хүчитгэсэн (SD40)	H32	tonf	12.675		12.675	13.436	6 % хорогдол
		H29	tonf	24.669		24.669	26.149	6 % хорогдол
		Нийт	tonf	37.344		37.344	39.585	
		H25	tonf	26.496		26.496	28.086	6 % хорогдол
		H22	tonf	20.410		20.410	21.635	6 % хорогдол
		H19	tonf	14.814		14.814	15.258	3 % хорогдол
		H16	tonf	23.687		23.687	24.398	3 % хорогдол
		Нийт	tonf	85.407		85.407	89.376	
		H13	tonf	1.445		1.445	1.488	3 % хорогдол
		H10	tonf					3 % хорогдол
	Нийт		tonf	124.196		124.196	130.449	
	Хүчитгээгүй (SD30)	D32	tonf		2.486	2.486	2.635	6 % хорогдол
		D29	tonf					6 % хорогдол
		Нийт	tonf		2.486	2.486	2.635	
		D25	tonf		15.061	15.061	15.965	6 % хорогдол
		D22	tonf		1.476	1.476	1.565	6 % хорогдол
		D19	tonf		8.670	8.670	8.930	3 % хорогдол
		D16	tonf	3.060	14.732	17.792	18.326	3 % хорогдол
